

STEM Салбарт Суралцах Охидыг Дэмжих Тэтгэлэгт Хөтөлбөр



Women Empowerment Mongolia (WE Mongolia) нь АНУ-ын Виржиниа мужид бүртгэлтэй ашгийн бус эмэгтэйчүүдийн байгууллага. Манай байгууллага АНУ-ын Вашингтон мужийн Сиатл, Хойд Каролина мужийн Шарлот хотуудад салбартай бөгөөд Улаанбаатар хотод сайн дурын багийн бүрэлдхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Бидний эрхэм зорилго бол мэдээлэл, мэдлэг, менторт суурилсан нөлөөллийн хүрээг бэхжүүлэн, охид эмэгтэйчүүдэд STEM-ийн чиглэлээр суралцах боломжийг нээж, охидын манлайлалыг дэмжих замаар жендэрийн тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулах юм.

Тэтгэлэгийн Зорилго

- STEM (шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик)-ийн чиглэлээр суралцан, улмаар мэргэжлээрээ ажиллах чин хүсэлтэй, сурлага сайтай охидыг дэмжин, санхүүгийн болон техникийн түслэмж үзүүлэх.
- STEM-ийн салбар дахь жендэрийн харьцааг тэнцүүлэх, эрх тэгш боломжийг хангах тухай Тогтвортой Хөгжлийн 5-р зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Тэтгэлэгийн хүрээ

Тэтгэлэгийн анхан шатны сонгон шалгаруулалтыг МУИС, эцсийн шатны шалгаруулалтыг WE Mongolia ТББ хийж, жил бүр 2-р түвшний 5 эмэгтэй оюутныг шалгаруулан тус бүр 500,000 төгрөгийн тэтгэлэг олгоно. Мөн тухайн жилийн хичээлийн явцад техникийн ур чадварыг хөгжүүлэх, Англи хэл, хувь хүний хөгжлийн сургалт, семинарт оролцох боломжоор хангана.

Тавигдах Шаардлага

- 2021-2022 оны хичээлийн жилд 2-р түвшний суралцагч байх.
- STEM салбарын аль нэг чиглэлээр мэргэших зорилготой суралцагч байх. Үүнд: Компьютерийн ухаан, Мэдээллийн систем, Програм хангамж, Мэдээллийн технологи, Нано шинжлэх ухаан, Инженерчлэл, Хэрэглээний математик, Компьютерийн сүлжээ, Электроникийн хөтөлбөрийн суралцагч хамаарна.
- Сурлагын голч дүн 3.0 буюу түүнээс дээш байх.
- Эцэг/эх нь өрх толгойлсон ганц бие бөгөөд байнгын тодорхой орлоготой байх.
- Хөдөө орон нутгаас ирсэн болон эсвэл Сонгино-Хайрхан дүүргийн оршин суугч байх.
- Тэтгэлэгт хамрагдах хугацаандаа WE Mongolia ТББ-аас зохион байгуулж буй хүмүүнлэг, сайн дурын ажилд идэвхитэй оролцох.



STEM Салбарт Суралцах Охидыг Дэмжих Тэтгэлэгт Хөтөлбөр



- Өөрийн сонирхсон чиглэлээр хичээлээс гадуурх дугуйлан, эсвэл олимпиадад амжилттай оролцож, сайн дурын ажил хийж байсан туршлагатай байвал давуу тал болно.

Бүрдүүлэх Бичиг Баримтын Жагсаалт

1. Тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маягт
2. Ерөнхий Боловсролын гэрчилгээний хуулбар
3. Дүнгийн тодорхойлолт
4. Сургуулийн багш эсвэл менторын тодорхойлолт – 1 хувь
5. Оршин суугаа хаягын тодорхойлолт
6. Ганцаараа авахуулсан зураг – 1 хувь (сонгон шалгаруулалтанд тэнцсэн тохиолдолд байгууллагын цахим хуудсаар мэдээлэхэд ашиглана)

Нэмэлт материалууд:

7. Олимпиадад оролцож байсан бол, тодорхойлолт эсвэл гэрчилгээний хуулбар
8. Сайн дурын ажил хийж байсан бол, тодорхойлолт

Эцсийн шатанд шалгарсан 10 оюутан доорх сэдвээс аль нэгийг сонгон, 1-3 хуудас эсээ бичиж info@wemongolia.org хаягаар илгээнэ:

- Би яагаад _____ мэргэжлийг сонгосон бэ?
- STEM тэтгэлэгт хамрагдсанаар ямар боломж нээгдэж байна? Түүнийг хэрхэн ашиглах вэ?
- Ирээдүйн зорилго, төлөвлөгөө
- Чөлөөт сэдэв

Хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа:

2021 оны 11 дүгээр сарын 10 -ний өдрийн 12:00 цаг хүртэл СиСи системээр бүртгүүлж, тэтгэлгийн бүрдүүлэх бичиг баримтыг МУИС-ийн хичээлийн 2-р байрны 109 тоот өрөө, Оюутан, төгсөгчийн хэлтэст хүлээлгэн өгснөөр бүртгэл баталгаажна.

Мэдээлэл авах утас: 77307730-1514, 3400, n.altanzul@num.edu.mn

